



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны ᠐9 сарын ᠒᠐ өдөр

Дугаар А/᠒31.

Улаанбаатар хот

「Баянзүрх дүүргийн Цэдэн-Эрдэнэ өрхийн
эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,117,003.0 (есөн сая нэг зуун арван долоон мянга гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн Цэдэн-Эрдэнэ өрхийн эрүүл мэндийн төв (С.Энх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 12 нэр төрлийн 9,117,003.0 (есөн сая нэг зуун арван долоон мянга гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Баянзүрх дүүргийн Цэдэн-Эрдэнэ өрхийн эрүүл мэндийн төв (С.Энх-Эрдэнэ)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА



